

## МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2012 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр болж 1. Монголбанкны 2011 оны цэвэр орлогын хуваарилалт, нөөцийн сангийн байдал, 2. Эрсдэлийн удирдлагын талаар хэрэгжүүлж буй ажил, 3. Монголбанкны Хяналт шалгалтын газраас арилжааны банкуудад тавих хяналтыг сайжруулах талаар хийсэн ажлын үр дүн, 4. Монголбанкнаас дотоод аудитын талаар гаргасан журам, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн байдлыг шалгасан дүн зэрэг хэд хэдэн асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргасан байна.

**1.** 2011 онд Монголбанкны нийт хөрөнгө 3,976,214 сая төгрөг болж өмнөх оноос 28,3 хувиар, нийт өр төлбөр 3,942,068 сая төгрөг болж өмнөх оноос 21,5 хувиар өсч, 34,146 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Гадаадын банкинд байршуулсан хөрөнгийн хэмжээ өмнөх оноос хоёр дахин нэмэгдсэн мөн алт ба үнэт металлын гүйлгээ хоёр дахин өссөн нь нийт хөрөнгийн өсөлтөд нөлөөлснийг Хяналтын зөвлөл тэмдэглэсэн байна. 2011 оны эцэст Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэл 155,276 сая төгрөг, банкуудад олгосон зээл 340,581 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 102,232-210,190 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийт өр төлбөрийн буюу пассивын бүтцэд гарсан өөрчлөлт нь гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө, Төв банкны үнэт цаас, банкуудын харилцах, хадгаламж, төрийн байгууллагуудад өгөх өр төлбөртэй холбоотой гүйлгээ байна. Төв банкны үнэт цаасны үлдэгдэл 879,113 сая төгрөг болж өмнөх оноос 20 хувиар буурчээ. Сангийн яамны харилцах болон хадгаламжийн дансад байршсан мөнгөний үлдэгдэл 1,170,890 сая төгрөг болж, өмнөх оноос 42,5 хувиар өсчээ.

Тайлант хугацаанд Монголбанкны дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт гараагүй байна. Урьд жилүүдээс хуримтлагдсан алдагдал 91,799 сая төгрөг болж, өмнөх оноос (34,331 сая төг) 57,468 сая төгрөгөөр нэмэгджээ.

2011 оны үр дүнгээр өмнөх оны алдагдал (145,5 тэрбум төгрөг)-ыг бүрэн нөхөж, Монголбанкны цэвэр орлого 34,146 сая төгрөгөөр нэмэгдсэнийг тэмдэглэж, уг асуудлыг зохих журмын дагуу УИХ-д танилцуулах нь зүйтэй гэж үзжээ.

**2.** Монголбанкны Эрсдэлийн удирдлагын алба нь өөрийн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, эрсдэлийн удирдлагын талаар баримтлах бодлогыг боловсруулж мөрдүүлэх, эрсдэлийн талаар баримтлах заавар журмыг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангах, банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлон хянаж удирдах, гадаад валютын нөөцийг зохистой байршуулах, багцын бүтэц хийгээд лимитийг оновчтой тогтоох, тайлагнах, эрсдэлийн удирдлагыг сайжруулах талаар тодорхой санал боловсруулах, арилжааны банкуудад олгох зээлийн барьцаанд авах хөрөнгийн шалгуурыг тодорхойлох зэрэг асуудалд анхаарч ажилласныг Хяналтын зөвлөлийн шийдвэрт тэмдэглэсэн байна.

ЭУА-ны үйл ажиллагааны чиг үүрэгт Монголбанкинд учирч болох эрсдэлүүдийг бүрэн хамруулж чадаагүй, эрсдэлийн алба зарим чиг үүргээ хэрэгжүүлж эхлээгүй байна гэж Хяналтын зөвлөл үзэв.

Хяналтын зөвлөлөөс Монголбанкны удирдлагад доорх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна.

- Зах зээлийн харилцаа өндөр хөгжсөн орнуудын төв банкуудын эрсдэлийг тодорхойлж буй зарчимд нийцүүлэн Монголбанкны системийн хэмжээний эрсдэлийг тодорхойлох стратеги боловсруулж, хэрэгжүүлэхийн хамт ЭУА-ны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

- Монголбанкны системийн хэмжээний эрсдэлийг тодорхойлох стратеги боловсруулж хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрсдэлийн талаар мөрдөж байгаа эрх зүйн актыг хянан үзэж, шинэчлэх, боловсронгуй болгох арга хэмжээ авах.

**3.** Монголбанкны Хяналт шалгалтын газраас арилжааны банкуудад тавих хяналтыг сайжруулах талаар хийж байгаа ажилтай танилцсан тухай мэдээллийг хэлэлцээд санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх шаардлагад нийцүүлэн Монголбанкны хяналт шалгалтын дунд хугацааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх, түүнд хяналтын тогтвортой байдлыг хангах, үр дүнг дээшлүүлэх, хянан шалгагчдын ажлын нөхцлийг сайжруулах, бие дааж ажиллах, шалгалтын үр дүнгийн талаар тэдний хариуцлагыг дээшлүүлэх зэрэг асуудлыг тусгах нь зүйтэй гэж үзэв.

**4.** Монголбанкнаас дотоод аудитын талаар гаргасан журам, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй Хяналтын зөвлөл танилцаж, Монголбанкны ДАГ-ын үйл ажиллагаа тогтворжиж, ажлын ахиц өөрчлөлт гарч байгааг тэмдэглэн дотоод аудитын талаар дараах асуудалд анхаарах зөвлөмжийг Монголбанкны удирдлагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Дотоод аудитын газрын үйл ажиллагаанд одоо мөрдөж байгаа эрх зүйн актуудыг хянан үзэж, шинэчлэн баталж мөрдүүлэх;

- Зарим шалгалтын дүнг тухай бүр хэлэлцэж чадахгүй цаг хугацаа сунжирч байгаагаас шалгалтын үр дүнгээр авах арга хэмжээний ач холбогдол буурч байгааг анхаарч, шалгалтын дүнг шалгалт дууссанаас хойш тодорхой хугацааны дотор Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцэн холбогдох арга хэмжээ авдаг журам тогтоож мөрдүүлэхийг Монголбанкны удирдлагад зөвлөмж болгосон байна.

## **МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ**